

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ОНОЛ БА ЭКОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН АСУУДАЛД

Г. Баасанхүү*

I. Экологийн асуудлаар хийгдсэн онолын судалгаа

Олон улсын харилцааны онолын хөгжил “хүч” ба хүчний тэнцвэрийн ойлголтын талаар сургамжлах улс төрийн реалистуудын үзэл сургаальтай ихээхэн холбоо хамааралтай хөгжсөөр ирсэн. Үнэхээр улс хоорондын харилцааны түүхийг сөхөн үзвэл олон улсын харилцаа нь хүчний харилцаа байсаар ирсэн билээ. Идеалистууд, позитивистууд, глобалистууд гээд онолын урсгалууд реалистуудын үзэл сургаальтай эсрэгцэн хөгжсөөр ирсэн ч реалист онол өнөөдрийг хүртэл давамгайлсаар байна. Олон улсын харилцааны онолын хөгжлийн түүхэн дэх гурван их маргаан ч ямар нэг байдлаар реализмын эсрэг дэгдэж, олон улсын харилцааг “хүч”-ний гадна тайлбарлахыг оролдсон. Гэвч амжилтанд хүрээгүй. Энэ нь улс хоорондын харилцаанд хүчний тэнцвэр үйлчилсээр байгааг нотолсоор байгаа юм. Нөгөө талаар олон улсын харилцааны оролцогчид, орчин өөрчлөгдөхийн хэрээр “хүч”, “хүчний тэнцвэр”, “аюул занал” хэмээх реалист онолын сонгодог ухагдахуунууд улам бүр өөрийн мөн чанараа алдсаар байна. Сүүлийн үед ихэд шуугих болсон олон улсын глобал аюул заналуудын нэг болох экологийн (хүрээлэх орчны хямралууд) асуудлууд нь уламжлалт бус аюул заналын нэг мөн билээ.

“Хүйтэн дайн”-ы ид үе буюу 1970-аад оны дунд үед позитивистуудын онолын эрэл хайгуул олон улсын харилцааны улс төрийн үйл явцад цаашид нөлөөлөх хүрээлэн байгаа орчны асуудлыг анх сөхөн тавьсан бөгөөд хүрээлэх орчны парадигм гэсэн онолын шинэ чиглэлийг үүсгэн хөгжүүлсэн нь өнөөдөр олон улсын онолын бие даасан нэгэн дэг урсгал болтлоо хөгжөөд байна.

Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалтай холбогдох онолын судалгаа үндсэн хоёр чиглэлээр хийгдсэн гэж үзэж болох юм. Үүнд:

1. Олон улсын харилцааны системийн гадаад орчинтой холбогдуулсан судалгаа (M. & G.Sprouts, M.Merle);
2. Олон улсын харилцаанд өсөн нэмэгдэж байгаа харилцан хамааралтай холбогдуулсан судалгаа (Wight.M, Hurrel.A, Kingsbury.B, Myers.N).

Эхний буюу олон улсын харилцааны системийн онол ба системийн судалгаа нь хамгийн үр дүнтэй судалгааны чиглэл байдаг бөгөөд ихэнхдээ олон

* МУИС, ОУХС-ийн багш, докторант

улсын улс төрийн бүс нутгуудыг судлахад оновчтой арга барилд тооцогддог. Олон улсын харилцааны систем, түүний бүтэц болон оролцогчдод нөлөөлж байдаг ихэнх нөлөө буюу шахалт нь системээс бус, харин тухайн системийн гадаад орчинтой харилцах харьцаанаас үүддэг. Инвайромент буюу гадаад орчин нь системийг хүрээлэн оршиж, түүнд шахалт болон хязгаарлалт үзүүлж байдаг цаг агаар, газар зүйн байршил, хил хязгаарын байдал, хүрээлэл бөгөөд эдгээр нь олон улсын харилцааны үндсэн оролцогчид болох бүрэн эрхт улсууд болон бусад оролцогчдын харилцан үйлчлэлд нөлөөлж байдаг гэсэн үг юм.

Гэвч олон улсын харилцааны онолын хувьд хамгийн ярвигтай маргаантай тодорхойлолт нь олон улсын глобал буюу бүх дэлхийн системийн орчны талаарх төсөөлөл ойлголт байдаг. М.Мерль глобал олон улсын харилцааны системийн гадаад орчин нь зөвхөн хүрээлэн буй байгалийн хүрээлэлд тухайлбал, агаар мандал, нарны аймаг зэргээр л илэрч болно гэж үзсэн. Энэ тохиолдолд олон улсын харилцаа нь метеорологи юм уу астрологитай давхцах хэрэгтэй болно гэсэн [Merle.M.1988].

Харамсалтай нь олон улсын харилцааны хувьд ийн гадаад орчны талаарх судалгаа ялангуяа, глобал түвшинд хэт хийсвэрлэл шаарддаг учир дутагдалтай болохыг Маргарет ба Гарольд Спрутууд мөн анзааран шүүмжилсэн байдаг [Sprouts.H.&M.1968;1969]. Иймээс Д.Сингериин хувьд орчны талаарх ойлголт нь олон улсын харилцааны дэд системүүдийн судалгаанд үр дүнтэй байдаг байна [Singer.D.J.1971]. Өөрөөр хэлбэл, 1970-аад оноос олон улсын харилцааны системд хүрээлэх орчны нөлөө байнга тусч байдгийг судлаачид нэгэнт ажигласан бөгөөд үүнээс глобал олон улсын харилцааны системийн гадаад орчин нь хүрээлэн байгаа орчин болохыг онолын хувьд хүлээн зөвшөөрсөн гэсэн дүгнэлтийг хийж болно.

Хоёр дахь судалгааны чиглэл олон улсын харилцааны онолын позитивист урсгалын төлөөлөгчид, постпозитивистуудын парадигмтай холбоотой юм. Олон улсын харилцаан дахь харилцан хамаарал өсөн нэмэгдэхийн хэрээр уламжлалт улс хоорондын харилцаанд хүрээлэн байгаа орчинтой холбогдох экологийн болон бусад глобал асуудлуудыг шийдвэрлэх бодит шаардлага тулгарч эхэлсэн нь даяаршилтай холбоотой болохыг нотолсон судалгааг тэд идэвхтэй хийж эхэлсэн бөгөөд чухамдаа судалгааны эл чиглэлийн төлөөлөгчид хүрээлэн байгаа байгаль орчин, экологийн асуудлыг олон улсын харилцаатай холбон тайлбарласан шинэ онол, хандлагыг үүсгэн хөгжүүлсэн байдаг.

II. Хүрээлэх орчны улс төрийн онол

Үнэхээр шинэ уламжлалт бус аюул заналууд зөвхөн реалист онолд төдийгүй либерал урсгалын онолын бүтцэд нөлөөлөх болжээ. Аливаа улсын сүр хүчний илэрхийлэл эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч түүхий эдийн хомсдол, хөгжлийн хэт зөрүүтэй байдал, байгалийн гамшиг, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал ба хувь хүний аюулгүй байдлын асуудал гээд олон асуудал нь их гүрнүүдийн хүчний тэнцвэрийг зөв тодорхойлохыг шаардаж байна.

Бид чухам яагаад олон улсын харилцааны онолын хүрээнд хүрээлэн байгаа орчны асуудлыг сөхөн авч үзэх шаардлагатай болж байна вэ?

Хүрээлэх орчны улс төрийн онолыг үүсгэгч гэж үздэг Вайтын хэлснээр энэ онол зөвхөн сайхан амьдралын тухай санааг тунхаглах төдийгүй хүний сайн

сайхан оршин тогтнолд баталгаа олгох арга, арга замыг эрэлхийлдэг тул ач холбогдолтой юм [Wight.M.1966]. Өөрөөр хэлбэл, сонгодог реалист хийгээд идеалист онолын урсгалуудтай зэрэгцэн хүрээлэн байгаа орчны асуудлыг олон улсын харилцааны онолтой холбон үзэх гурван үндсэн шалтгаан байсан.

1. Хүн төрөлхтөн ба хүрээлэн байгаа орчны харилцааг урт удаан хугацаанд зохицуулах чадвар бүхий улс төрийн байгууллага байгаа эсэх тухай буюу хөгжлийг хязгаарлагч бодит (материаллаг) хязгаарыг тодорхойлох шаардлага.

Энэ нь өнөөдөр олон улсын харилцааны голлох тоглогчид гэгддэг үндэсний бүрэн эрхт улсуудын харилцааг зохицуулагч улс төрийн механизм, тэр дундаа олон улсын байгууллага (ОУБ)-ууд нь бодитойгоор хүрээлэн байгаа орчны асуудлуудыг шийдвэрлэх боломжтой, үгүйг судлахын хамт шинэ механизм үүсгэх шаардлага байгаа эсэхийг судлахад чиглэгддэг [Hurrell.A.,Kingsbury.B.1992]. Олон улсын харилцааны орчны онолын томоохон төлөөлөгч Э.Харрелл глобал хүрээлэн байгаа орчныг удирдахад төрийн тогтолцоо сөргөөр нөлөөлж байдаг гэж хүртэл үзсэн.

2. Хүрээлэн байгаа орчин маань өөрөө глобал хэлэлцүүлгийн талбар болсныг хүлээн зөвшөөрөх шаардлага.

Хувь хүн болгоны аюулгүй байдлын асуудлыг хөндсөн экологийн асуудлууд нь зөвхөн олон улсын үр дүнтэй идэвхтэй хамтын ажиллагааны дүнд сая зохицуулагдах боломжтой. Бүс нутгийн заримдаа орон нутгийн чанартай олон асуудлууд, ой устгах, усны хомсдол, эрчим хүчний дутагдал зэрэг нь баян болон ядуу улсуудын хөгжлийн ялгааг улам холдуулж, дотоодын болон олон улсын хямрал мөргөлдөөний шалтгаан болж байгаа. Нөгөөтэйгүүр хэдийгээр эдгээр нь тухайн улсын эсвэл бүс нутгийн чанартай асуудал мэт боловч шалтгаан нь үндэсний хил хязгаарын гадна байдаг. Өнөөдрийн Зүүн Азийн улсуудын толгойны өвчний нэг шар шороон шуурганы асуудал нь Солонгос, Хятад, Монголын хувьд адил хамааралтай боловч асуудлыг зохицуулахын тулд Монголын эдийн засаг, цөлжилттэй тэмцэх хэрэгтэй байх жишээтэй. Глобал экологийн тэсрэлт нь биднийг уламжлалт болон уламжлалт бүс сэтгэлгээ асар заагтай болсныг ойлгуулж өгсөн гэж үзсэн Жон Рагги бид эх дэлхийгээ аврахаар “озоны дипломат ажиллагааг” явуулж, гэрээ хэлэлцээр хийж, онолын түвшинд үр дүнг нь тодорхойлон судлахыг хичээдэг ч бодит байдал дээр улс төвтэй хүчний тэнцвэрийн судалгаандаа илүү анхаарсаар байна гэж үзсэн [Ruggie.J.G.1993]. Өөрөөр хэлбэл, олон улсын харилцааны онол ба хүрээлэн байгаа глобал орчин гэсэн хоёр өөр сэтгэлгээг эсрэгцүүлэн бас нэгтгэхийг оролдсоор байна гэсэн үг юм.

3. Даяаршилтай холбоотой дэлхийн эдийн засаг ба хүрээлэн байгаа орчны асуудлын харилцан хамаарлыг зохицуулах шаардлага.

Хөгжил хурдсахын хэрээр түүний хурдыг түүхий эд гүйцэхгүй, хангаж чадахгүй болж байгаа нь өөрөө даяаршлын хамгийн эмзэг асуудал болоод байна. Нөгөөтэйгүүр энэ асуудал олон талаар хөгжлийн хэт зөрүүтэй байдал, орлогын тэгш бус хуваарилалт буюу Умард, Өмнөдийн харилцаатай шууд холбоотой юм. Иймээс хүрээлэн байгаа орчны асуудлыг ярихад хүрэхэд олон улсын харилцааны оролцогчдын талаар, “Ромын клуб” болон “Дэлхий гариг”-ийг олон улсын харилцааны оролцогчоор хүлээн зөвшөөрөх эсэх, өрнөдийн ардчилсан хөгжлийн загвараас гадна бусад загвар байгаа эсэхийг, дэлхийн хөгжлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлохыг шаарддаг. Энэ нь нэг талаас улстөрийн

эдийн засаг болон неомарксистуудын онолын судалгааг гарцаагүй хүрээлэн байгаа орчинтой холбож байдаг [Holmberg.J. 1992].

Энэ утгаар хүрээлэн байгаа орчны асуудал маань өөрөө олон улсын харилцааны онолын үндсэн судлагдахуун болох олон улсын харилцааны зүй тогтлыг илрүүлэх, олон улсын харилцааны ирээдүй ямар байхыг төсөөлөх гэсэн асуудлыг тайлбарлах бие даасан тайлбарыг өгч байдаг. Магадгүй хүрээлэн байгаа орчин олон улсын харилцааны онолын их маргаануудыг таслан, нэг нь нөгөөгөө эс хүлээн зөвшөөрдөг олон улсын харилцааны үндсэн урсгалуудын үзэл хандлагыг ойртуулах, нэгтгэх боломжийг үүсгэж байна гэж үзэж болно.

Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах нь улс үндэстэн болгоны мөнхийн эрх ашиг, оршин тогтнолтой, их гүрнүүдийн хүчний тэнцвэртэй, олон улсын харилцааны бусад тоглогчид болох ОУБ-уудын идэвхтэй үйл ажиллагаанаас, хувь хүн бүрээс, улс орнуудын улс төр, эдийн засгийн хөгжлөөс шууд хамааралтай учир онолын урсгал бүрийн судалгааны үндсэн объектыг цэнхэр гариг ба хүрээлэн байгаа орчин өөрөө нэгтгэн холбож чадаж байгаа юм.

III. Олон улсын харилцаа ба багийн тоглолт

Нэгэнтээ Жон Данн “улс төрийн онолын зорилго нь бодит бэрхшээлыг үнэлж, түүнийг хэрхэн даван туулахыг заахад оршдог. Үүний тулд гурван зүйлийг шийдвэрлэхэд суралцах нь чухал юм. Энэ нь өнөөгийн бидний амьдралын нийгэм, улс төр, эдийн засгийн зохион байгуулалт, нөхцөл байдал ямар байгааг тодорхойлох, ойрын болон алсын ирээдүйд бид энэ амьдралаа ямраар харахыг хүсч байгааг тодорхойлох, одоогийн байдлаас харахад бидний харахыг хүсч байгаа ертөнц (world)-ийн загвартай ирээдүй хэр дөхөж байгааг үнэлэх явдал бөлгөө” гэж хэлсэн нь оновчтой байжээ [Dunn.J. 1992].

Монголчууд бид цаг хугацаа бүхнийг харуулна гэж ярих дуртай байдаг. Ж.Раггигийн тодорхойлсон онолын гурван зарчмын хүрээнд өнөөдөр үйлчилж буй дэлхийн бодлогыг зохицуулагч механизм (G-8), ирээдүйд бидний хүсч байгаа тэр сайн сайхан ирээдүйн төлөө глобал аюул заналтай, экологийн асуудалтай хэрхэн тэмцэх вэ, тэмцэх боломж байгаа бол ямар арга замаар гэдгийг тодорхойлох нь нэн чухал тул өөрийн зарим нэг саналыг та нөхдүүдтэй хуваалцахыг зорилоо. Өөрөөр хэлбэл, бидний оршин амьдарч байгаа дэлхий хэмээх цэнхэр гариг маань хүн төрөлхтний эрчимтэй хөгжлийн даацыг дийлэлгүй бодит глобал аюул заналыг үүсгэж байгаатай холбоотой юм. Түүнээс хэрхэн урьдчилан сэргийлж, үндэсний аюулгүй байдал, олон улсын аюулгүй байдал, цаашлаад хүн төрөлхтний оршин тогтнолыг яаж хангах вэ гэдэг асуудал зүй ёсны тулгамдсан бөгөөд хүн бүгдийн санаа зовинох асуудал мөн. Жишээ нь “хүйтэн дайн”-ы үед ч юм уу, эс бөгөөс Наполеон Бонапартын эзэнт гүрний дараа Европын олон улсын харилцааг тодорхойлж асан Венийн системийн үед улс гүрнүүд байгаль болон хүрээлэн байгаа орчинтой холбон аюулгүй байдлаа тайлбарлах тухай бодож үзээгүй байсан болов уу. Тэд аюулгүй байдлаа хүчирхэг хөрш, хүчирхэг өрсөлдөгчийг хэрхэн ялан дийлэхтэй холбон эс бөгөөс өөрийн манлайлах (hegemony) эрмэлзэлтэй холбон үнэлж байлаа.

Анх XX зууны дунд үеэс байгаль цаг агаар, хүрээлэн байгаа орчны хурдтай өөрчлөлтийн талаар санаа зовнисон үг яриа сөхөгдсөөр ирсэн боловч хүн төрөлхтөн эл асуудалд “хүйтэн дайн” төгссөнөөр буюу зарим утгаараа хий

хоосон үзэл суртлын дайны аюулыг үүсгэж асан хоёр туйлт тогтолцоо нуран унасны дараа сая бодитойгоор анхаарал хандуулж эхлэв.

Хэдийгээр өнөөдөр олон улсын харилцааны халуун цэг болоод байгаа Иракийн дайн болон Ойрхи Дорнодын асуудал нь их гүрнүүд хийгээд улс үндэстнүүдийн үндэсний ашиг сонирхлынх нь илэрхийлэл байж, олон улсын харилцаа хүчний тэнцвэр дээр оршсоор байгаа боловч, хүчтэй нь хүчгүйгээ буюу тэг хувилбартай тоглоомын онол үйлчилсээр мэт боловч бодит байдал дээр олон тооны чанарын өөрчлөлтүүд гарч байгааг олон улсын харилцааны онолд хүлээн зөвшөөрөх шаардлагатай болжээ.

Даяаршил, интеграцчлал гэж ярьсаар байгаа “Их 8”-ын уулзалтаар дэлхийн бодлогыг тодорхойлолцогч их гүрнүүд хүчний давуу байдлыг олж авах үндэсний ашиг сонирхлоосоо хамааран өөр хоорондоо ил далд зөрчилдсөөр. Нэг зэрэг хүн төрөлхтний ирээдүйн сайн сайхны төлөө хамтран ажиллахаар зөвшилцсөөр. Олон улсын эдийн засгийн харилцаа, дэлхийн эдийн засгийн хурдтай хөгжил нь техник технологийн дэвшилтэй уялдаад бидний 200 гаран улсыг жижиг том, их багаас үл хамааран нягт харилцан хамааралд нэгэнт оруулжээ.

Э.Валлерштайны үзэж байгаачлан дэлхий “төв” ба “зах хязгаар” буюу хөгжлийн эрс ялгаа бүхий Умард-Өмнөдийн харилцаагаар тодорхойлогдсоор байгаа гэж үзвэл үүнд эдийн засгийн өндөр хөгжилтэй “төв”, хөгжиж байгаа “зах хязгаар”-ын түүхий эдээс улам бүр хамааралтай болох хэв шинж ажиглагдсаар байна [Валлерштайн.И. 1998]. Эл нөхцөлд харилцан нэгнээ нөхсөн хамтын тоглоомын дүрэм гарцаагүй үйлчилж эхэлж байгаа юм.

Хүссэн ч, хүсээгүй ч өөр хоорондоо өрсөлдөх их гүрнүүд харилцан нэгнээсээ төдийгүй хаа тэртээх Африкийн, магадгүй Монгол улсын байдлаас хамраалтай болж байна гэсэн үг. Ийм учраас “хүч”-ийг сонгодог утгаар нь ойлгож, аюулгүй байдлыг тогвортой байдлаар тодорхойлж байгаа өнөөгийн олон улсын харилцаанд хамтын аюулгүй байдлын онол, ардчилсан реализмын зарчим хүч түрэн, нөлөөтэй болж байх шиг байна. Гэвч “хүч”, “аюул занал”-ыг сонгодог утгаар нь ойлгосон хэвээр. Бид чинь үнэндээ XIX зуунаараа сэтгэсээр хөгжлөөсөө хоцорч байх шиг. Түүхий эд, эрчим хүчний нөөцийн хурдтай хомсдол, цаг уурын өөрчлөлт, дулаарал, цөлжилт, цунами энэ бүгд өөрөөр хэлбэл, бидний хайнга хандаж, хайрлалгүй үрсээр ирсэн эх дэлхий, хүрээлэн байгаа орчин маань өнөөдөр биднээс тоглоомын шинэ дүрэм шаардаж байна. Аливаа улс оршин тогтнохын тулд хөгжихийн төлөө үндэсний ашиг сонирхлоо тодорхойлдог гэж үзвэл тэр ашиг сонирхолд улс хоорондын харилцаан дахь ашиг сонирхлыг илэрхийлсэн хамтын ажиллагааг хүлээн зөвшөөрсөн бодит зарчмыг тунхаглах цаг болжээ.

2005. онд Нобелийн шагнал хүртсэн Томас Шеллингийн онол үнэндээ бидэнд хэрэгтэй байгаа тэр тоглоомын дүрмийг тодорхойлохыг оролдсоноороо агуу бөлгөө. Хэрвээ амьдралын аливаа үзэгдлийг тоглоом гэж үзвэл тэрбээр өөрийн дүрэмтэй, оролцогчидтой байдаг. Ямар ч тоглоомд оролцон тоглогч хожихыг эрмэлздэг. Харин хожихын тулд дүрмийн дагуу чадварлаг тоглох хэрэгтэй.

Өнөөдрийн олон улсын харилцааны улс төрийн үйл явцын өрнөлийг харахад глобал асуудлууд биднийг хамтарч нэг багт орж тоглохыг шаардаж байгаа бөгөөд их гүрнүүд ч үүнийг сайтар ухамсарлаж байгаа нь харагддаг. Гэвч харамсалтай нь тэдний олонхид нь багийнхаа “од” байх хийрхэлийн өвчин буюу

олон улсын харилцаанд тэргүүлэх, ноёрхох ашиг сонирхол байсаар байна. Багаар тоглож байгаа тохиолдолд гол тоглогч чухал үүрэгтэй ч хамгийн чухал нь харилцан нэгнээ мэдэрч тоглох чадвар буюу хамтаар идэвхтэй тоглох зарчим шийдвэрлэх үүрэгтэй байдаг.

Магадгүй та хөл бөмбөгийн хорхойтон бол Францын багийг хэн ч амжилттай тоглоно гэж зүүдлээгүй байтал тэд амжилтанд хүрсэн төдийгүй, хөл бөмбөгийн олон хорхойтныг алмайруулж, 2006 оны дэлхийн аваргын цомын төлөө шийдвэрлэх тулааныг хийж чадсан сэтгэл догдлуулсан тэр агшныг санаж байгаа болов уу. Францын шигшээ баг Зидан, Анре байгаад бус, тэд мэдэрч тоглож чадсандаа өөрөөр хэлбэл, багаар тоглож чадсан учраас өндөр амжилтанд хүрсэн.

Хэрвээ глобал асуудалтай тэмцье гэвэл ийм л багийн тоглолт хэрэгтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл, хүчтэй өрсөлдөгчийн эсрэг хамтран тоглож байгаа их гүрнүүд “од” болох зорилготой амиа бодсон тоглолтоос илүү, ялахын төлөө хамтын тоглолт хийх цаг болжээ.

Хөгжлийн чиг хандлага ч өөрөө ийм нөхцлийг үүсгэж байна. Бид хүн төрөлхтний оршин тогтнолын төлөө, улс орныхоо цэцэглэлт хөгжилтийн төлөө хар, шар, цагаан арьсны өнгөөсөө үл хамааран, хөгжилтэй хөгжилгүй эдийн засгийн байдлаасаа үл хамааран үг тунхаглалаар, бодит үйл ажиллагаагаараа хамтрах цаг болжээ. Үүний тод илрэл нь 2007 оны Германд болсон “Их 8”-ын уулзалтаар хүлэмжийн асуудлаар тохиролцсон зөвшилцөл бөлгөө. Хүчтэй нь хүчгүйгээ ялан дийлж бус, харин хүчтэй нь бусадтайгаа хамтарч хожих буюу түншлэлийн тэнцвэрийг үүсгэх нь чухал байна.

Баг доторх түншүүд нь хэдий өрсөлдөгчид боловч тэд зөвхөн хамтарснаар өөрийн зорилгодоо хүрдэг, илт давуу өрсөлдөгчөө дардаг, харилцан ашигтай байж чаддаг гэж үзвэл хүчний бус, зөвхөн “түншлэлийн тэнцвэр”-ийг үүсгэснээр глобал асуудлыг зохицуулах, тэр дундаа хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах боломжтой юм. Цаг үеэ мэдэрч сэтгэх цаг болсныг их гүрнүүдэд уриалмаар байна. Багийн тоглоомд гол тоглогчид чухал үүрэгтэй байдгийн адил хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангахад их гүрнүүдийн үүрэг роль чухал хэвээр байгаа, цаашид ч байхыг онцлох нь зүйтэй болов уу. Холбогч, дамжуулагч, довтлогч хэр амжилттай хамтрахаас хаалганд бөмбөг оруулах амжилт хамаардгийн нэг адил “Их 8” болон бүс нутагт нөлөөтэй бусад улсуудын хамтын тоглолтоос бидний ирээдүй, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал шууд хамаарна гэсэн онолын санааг дэвшүүлж байна.

Хүч сонгодог хүч бус, өөрөөр хэлбэл, аль нэгэн илүү хүчирхэг өрсөлдөгч улсын эсрэг чиглэж, хуримтлуулсан хүч бус харин шинэ төрлийн хүч болж байгааг /хамтын хүч/, харин өрсөлдөгч дайсан тань хэн нэгэн хүчирхэг хөрш болоод дэлхийн их гүрэн бус харин хүрээлэн байгаа орчны аюул болоод байгааг ухаарцгаая. Энэ тохиолдолд гарцаагүй хамтын тоглоомын дүрэм хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, өнөөдрийн төлөө хүчээр дулдуйдан өрсөлдөх биш харин ирээдүйнхээ төлөө хамтын тоглоомын дүрмийг бодитойгоор мөрдөх цаг болжээ.

Эцэст нь нэгэн цагт Сократ шавьдаа “Хэрвээ чамаас -Чи хэн бэ, аль полисын иргэн бэ? гэвэл -Афиных ч биш, Спартых ч биш, харин Дэлхийн иргэн гэж хариулаарай” гэсэн агуу үгээр төгсгөө.

Бид жижигхэн цэнхэр дэлхий гэдэг нэг л гаригийн иргэд билээ.

Нэмзүй

- Merle.M.Sociologie des relations internationals.P.,1988.p122
- Sprouts.H.&M. Environmental Factors in the Study of International Politics// James N.Rosenau(Ed.).International Politics and Foreign Policy .N.Y 1969.
- Sprouts.H.&M.An Ecological Paradigm for the Study of International Politics.Princeton.,1968. p14
- Singer.D.J.The Global System and its Sub-System.A Developmental View.N.Y.,1971.p132
- Wight M.Why is there no international theory?// H.Butterfield, M.Wight(eds).Diplomatic Investigations:Essays in the Theory of International Politics, L.:Allen&Unvin,1966.P.17-34
- Hurrell.A., Kingsbury.B.(eds).The International Politics of the Environment. Oxford: Oxford University Press.,1992 6-р бүлэг
- Ruggie.J.G.Teritoriality and beyond// International Organization.1993.Vol.47,'1.P.139-174
- Holmberg.J.Policies for a Small Planet.L.:Earthscan.,1992
- Dunn.J.Reinterpreting Political Responsibility.Cambridge:Polity Press,1992
- Валлерштайн.И.Анализ мировых систем:современное системное видение мирового сообщества// Социология на пороге XXI века: новые направления исследований.М.,1998